



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн салбарын урт хугацааны хөгжлийн бодлогыг олон улсын болон бүс нутгийн хөгжлийн чиг хандлага, хөрш орнуудын хөгжлийн бодлоготой уялдуулан шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хүчин төгөлдөр үйлчилж байгаа урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилттэй уялдуулан боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг 2019 оны 6 дугаар сарын сарын 10-ны дотор боловсруулж, дуусгах арга хэмжээ авахыг Ажлын хэсгийн ахлагч /Э.Мөнхнасан/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авч ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ж.Сэрээтэр/-д даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД

